



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/6024

Улаанбаатар хот

Г “Багачууд хүнс” ОНӨААТҮГ-ын хөрөнгийг
данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан 10,806,500 /арван сая найман зуун зургаан мянга таван зуун/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг “Багачууд хүнс” ОНӨААТҮГ /Б.Мөнхнасан/-т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг “Багачууд хүнс” ОНӨААТҮГ /Б.Мөнхнасан/-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГА

М.БАЯРАА



115060001509

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
 даргын оны сарын өдрийн
 тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: "Багачууд Хүнс" ОНӨААТҮГ

д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт хүчил	Ашиглалта нд орсон огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хуримтлаг дсан элэгдэл	Үлдэгдэл	Дансны нэр	
								Нэгж үнэ	Нийт үнэ			Шилжүүлэх данс	Бүртгэх данс
1	Гулсуур	хятад	төмөр	2019	сайн	ш	1	4,800,000.0	4,800,000.0	-	4,800,000.0	Хангамж материал	Бусад хөрөнгө
2	Зургийн аппарат	япон	22 MP	2015	сайн	ш	1	1,000,000.0	1,000,000.0	-	1,000,000.0	Хангамж материал	Машин тоног төхөөрөмж
3	Халаагч	хятад	220 втг	2015	Дунд	ш	1	450,000.0	450,000.0	-	450,000.0	Хангамж материал	Машин тоног төхөөрөмж
4	Цаг бүртгэлийн төхөөрөмж	хятад	1102	2019	сайн	ш	1	800,000.0	800,000.0	-	800,000.0	Хангамж материал	Машин тоног төхөөрөмж
5	Цахилгаан жин	хятад	150 кг	2017	Дунд	ш	1	632,000.0	632,000.0	-	632,000.0	Хангамж материал	Машин тоног төхөөрөмж
6	Хяналтын камер	хятад	50 GB	2016	Дунд	ш	11	284,045.5	3,124,500.0		3,124,500.0	Хангамж материал	Машин тоног төхөөрөмж
Нийт хөрөнгийн дүн								7,966,045.46	10,806,500.00	-	10,806,500.00		